**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Баянхонгор аймгийн Мал эмнэлэгийн газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/10/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2024.02.16


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Б.Наранцэцэг
Утас: 88093788 Цахим хаяг: narantsetsegbat@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** 3
**Асуудлыг онцолсон хэсэг** 3
**Аудитын гол асуудал** 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** 16
**4.1 Ерөнхий зүйл** 16
**4.2 Материаллаг байдал** 17
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** 18
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** 18
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** 18
**5.1 Төлбөрийн акт** 18
Төлбөрийн акт тогтоох нөхцөл байдал илрээгүй. 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандандзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.19 № 2/12

танай ______ -ны № ______ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оны гүйцэтгэлийн

5020081

төлөвлөгөөний биелэлтийг 3 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 98.3 хувьтай тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн тайлан бусад үйл ажиллагааны тайлан мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

5020081

2022.02.28

procurement. bayankhongor@audit.gov.mn
64101 · (976) 70442584
310 · 3

ᠪᠠᠶᠠᠷᠮᠠᠭᠨᠠᠢ · ᠪ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠭᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯ᠎ᠠ ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡ

ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠦᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠲᠠᠢ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠵᠡᠢ ᠃

ᠮᠡᠳᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠮᠡᠳᠡᠭᠳᠡᠯ ᠦᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **170,362,374.22** | **223,295,724.37** |
| **33** | **АВЛАГА** | 1,100,000.00 | 1,627,720.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,100,000.00 | 1,627,720.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,100,000.00 | 1,627,720.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 169,262,374.22 | 221,668,004.37 |
| **351** | **Түүхий эд материал** | 129,684,502.32 | 181,033,835.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 90,970,661.61 | 118,555,805.04 |
| 35130 | Эм боох материал | 38,713,840.71 | 62,478,029.99 |
| **354** | **Хангамжийн материал** | 37,767,871.90 | 39,094,169.34 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,027,175.00 | 7,312,955.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,054,873.00 | 24,958,173.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 599,283.90 | 2,004,441.34 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,426,540.00 | 4,818,600.00 |
| 35600 | Мал амьтад | 1,810,000.00 | 1,540,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,172,149,754.96** | **1,908,354,219.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,172,149,754.96 | 1,908,354,219.05 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,031,826,004.90 | 1,768,030,468.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 64,691,600.00 | 64,691,600.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (34,983,106.08) | (43,728,882.60) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 616,913,629.67 | 1,485,622,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (249,132,291.12) | (211,307,218.29) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 973,379,176.68 | 967,586,234.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (383,234,349.65) | (530,350,228.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,452,700.00 | 66,284,200.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24,261,354.60) | (30,767,235.72) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 140,323,750.06 | 140,323,750.06 |
| 39301 | Програм хангамж | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (981,249.94) | (981,249.94) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 139,025,000.00 | 139,025,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,342,512,129.18** | **2,131,649,943.42** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,336,950,995.78** | **2,131,649,943.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,336,950,995.78 | 2,131,649,943.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 139,025,000.00 | 139,025,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 139,025,000.00 | 139,025,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,143,248,345.71 | 1,937,947,293.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,143,248,345.71 | 1,143,248,345.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 794,698,947.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 54,677,650.07 | 54,677,650.07 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,342,512,129.18** | **2,131,649,943.42** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,325,228,104.08** | **4,145,420,886.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **558,371,988.28** | **1,701,518,766.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 558,371,988.28 | 1,701,518,766.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 558,371,988.28 | 1,701,518,766.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,528,400.00 | 4,082,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 555,843,588.28 | 1,697,436,266.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,766,856,115.80** | **2,443,902,120.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 959,691,600.00 | 1,273,311,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 959,691,600.00 | 1,273,311,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 807,164,515.80 | 1,170,591,020.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 657,112,460.00 | 728,098,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 149,644,055.80 | 442,493,020.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,578,776,030.81** | **3,350,571,938.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,578,776,030.81** | **3,350,571,938.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,527,963,239.61 | 3,304,862,801.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 559,837,160.00 | 995,399,114.45 |
| 210101 | Үндсэн цалин | 434,852,071.00 | 617,571,482.45 |
| 210102 | Нэмэгдэл | 74,217,831.90 | 231,609,131.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,002,999.10 | 53,713,687.00 |
| 210104 | Урамшуулал | 11,764,258.00 | 92,504,814.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх** | 70,383,922.00 | 126,319,067.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,681,400.00 | 85,262,567.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,491,900.00 | 10,264,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,128,322.00 | 8,211,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,098,400.00 | 2,052,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,983,900.00 | 20,528,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,802,377.00 | 22,067,458.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,814,129.00 | 3,701,287.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,600,000.00 | 14,965,923.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,388,248.00 | 3,400,248.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,914,095.57 | 38,353,086.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,141,200.00 | 4,258,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,651,004.56 | 25,274,577.56 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,909,700.00 | 4,318,817.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | 178,800.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,067,400.00 | 3,900,992.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 732,850,501.51 | 891,453,209.65 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 732,850,501.51 | 891,453,209.65 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,036,200.00 | 22,758,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 137,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,036,200.00 | 22,620,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,320,000.00 | 9,048,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,320,000.00 | 9,048,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 821,909,690.00 | 894,465,930.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 812,120,890.00 | 887,475,750.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 605,100.00 | 296,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 880,100.00 | 869,580.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 335,100.00 | 528,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,740,000.00 | 4,740,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 164,300.00 | 556,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 263,909,293.53 | 304,998,785.15 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 902,924.00 | 620,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 265,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 263,006,369.53 | 304,113,785.15 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50,812,791.20 | 45,709,137.29 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,050,400.00 | 32,814,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,476,800.00 | 32,814,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,762,391.20 | 12,895,037.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,762,391.20 | 12,895,037.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(253,547,926.73)** | **794,848,947.64** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 415,000.00 | 150,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 415,000.00 | 150,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (415,000.00) | (150,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(253,962,926.73)** | **794,698,947.64** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,769,384,515.80** | **2,447,984,620.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,528,400.00** | **4,082,500.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 2,528,400.00 | 4,082,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,528,400.00 | 4,082,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,528,400.00 | 4,082,500.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,766,856,115.80** | **2,443,902,120.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 959,691,600.00 | 1,273,311,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 959,691,600.00 | 1,273,311,100.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 807,164,515.80 | 1,170,591,020.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 657,112,460.00 | 728,098,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 149,644,055.80 | 442,493,020.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,769,384,515.80** | **2,440,217,120.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,769,384,515.80** | **2,440,217,120.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,718,470,324.60** | **2,394,507,982.71** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 556,952,848.60 | 998,035,514.85 |
| 210101 | Үндсэн цалин | 431,967,759.60 | 620,207,882.85 |
| 210102 | Нэмэгдэл | 74,217,831.90 | 231,609,131.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,002,999.10 | 53,713,687.00 |
| 210104 | Урамшуулал | 11,764,258.00 | 92,504,814.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,649,100.00 | 128,301,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,681,400.00 | 87,245,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,491,900.00 | 10,264,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,393,500.00 | 8,211,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,098,400.00 | 2,052,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,983,900.00 | 20,528,300.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,802,377.00 | 22,067,458.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,814,129.00 | 3,701,287.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,600,000.00 | 14,965,923.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,388,248.00 | 3,400,248.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 23,952,300.00 | 27,058,259.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,568,800.00 | 3,509,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,473,100.00 | 14,868,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,209,700.00 | 4,345,317.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 178,800.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,521,900.00 | 3,735,942.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 20,043,070.00 | 3,207,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,443,070.00 | 3,207,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,687,500.00 | 24,164,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,690,000.00 | 564,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,997,500.00 | 23,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,378,000.00 | 9,990,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,378,000.00 | 9,990,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,011,136,749.00 | 1,181,417,750.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,008,547,949.00 | 1,174,181,570.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 605,100.00 | 296,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 880,100.00 | 869,580.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 335,100.00 | 528,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 540,000.00 | 4,986,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 164,300.00 | 556,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 868,380.00 | 265,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 265,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,914,191.20** | **45,709,137.29** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,151,800.00 | 32,814,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,476,800.00 | 32,814,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,762,391.20 | 12,895,037.29 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,762,391.20 | 12,895,037.29 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **7,767,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **7,767,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **7,767,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 7,767,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 7,767,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(7,767,500.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 54,677,650.07 | 1,397,211,272.44 | 0.00 | 1,451,888,922.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **54,677,650.07** | **1,397,211,272.44** | **0.00** | 1,451,888,922.51 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 139,025,000.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 139,025,000.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -253,962,926.73 | 0.00 | -253,962,926.73 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **139,025,000.00** | **54,677,650.07** | **1,143,248,345.71** | **0.00** | 1,336,950,995.78 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **139,025,000.00** | **54,677,650.07** | **1,143,248,345.71** | **0.00** | 1,336,950,995.78 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **139,025,000.00** | **54,677,650.07** | **1,143,248,345.71** | **0.00** | 1,336,950,995.78 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 794,698,947.64 | 0.00 | 794,698,947.64 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **139,025,000.00** | **54,677,650.07** | **1,937,947,293.35** | **0.00** | 2,131,649,943.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувиар |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,275,811,100.00 | 1,271,530,862.71 | 4,280,237.29 | 99.7% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,275,811,100.00 | 1,271,530,862.71 | 4,280,237.29 | 99.7% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,242,997,000.00 | 1,238,716,762.71 | 4,280,237.29 | 99.7% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 998,115,900.00 | 998,035,514.85 | 80,385.15 | 100.0% |
| 210101 | Үндсэн цалин | 655,688,900.00 | 620,207,882.85 | 35,481,017.15 | 94.6% |
| 210102 | Нэмэгдэл | 273,321,500.00 | 231,609,131.00 | 41,712,369.00 | 84.7% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,766,000.00 | 53,713,687.00 | (13,947,687.00) | 135.1% |
| 210104 | Урамшуулал | 29,339,500.00 | 92,504,814.00 | (63,165,314.00) | 315.3% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 131,101,800.00 | 128,301,800.00 | 2,800,000.00 | 97.9% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,045,300.00 | 87,245,300.00 | 2,800,000.00 | 96.9% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,264,100.00 | 10,264,100.00 | - | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,211,300.00 | 8,211,300.00 | - | 100.0% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,052,800.00 | 2,052,800.00 | - | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,528,300.00 | 20,528,300.00 | - | 100.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,917,800.00 | 22,067,458.86 | 850,341.14 | 96.3% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,433,200.00 | 3,701,287.00 | 731,913.00 | 83.5% |
| 210302 | Түлш, халаалт | 15,079,400.00 | 14,965,923.86 | 113,476.14 | 99.2% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,405,200.00 | 3,400,248.00 | 4,952.00 | 99.9% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,072,100.00 | 27,058,259.00 | 13,841.00 | 99.9% |
| 210401 | Бичиг хэрэг | 3,509,000.00 | 3,509,000.00 | - | 100.0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,868,000.00 | 14,868,000.00 | - | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,359,100.00 | 4,345,317.00 | 13,783.00 | 99.7% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,736,000.00 | 3,735,942.00 | 58.00 | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | 3,501,800.00 | 3,207,600.00 | 294,200.00 | 91.6% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,207,600.00 | 3,207,600.00 | - | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,932,000.00 | 31,932,000.00 | - | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,332,000.00 | 8,332,000.00 | - | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 23,600,000.00 | 23,600,000.00 | - | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,990,100.00 | 9,990,100.00 | - | 100.0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,990,100.00 | 9,990,100.00 | - | 100.0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам** | 18,095,500.00 | 17,859,030.00 | 236,470.00 | 98.7% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,735,100.00 | 10,622,850.00 | 112,250.00 | 99.0% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 296,500.00 | 296,500.00 | - | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 885,400.00 | 869,580.00 | 15,820.00 | 98.2% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 561,800.00 | 528,000.00 | 33,800.00 | 94.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,004,700.00 | 4,986,000.00 | 18,700.00 | 99.6% |
| 210807 | Газрын төлбөр | 580,500.00 | 556,100.00 | 24,400.00 | 95.8% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 270,000.00 | 265,000.00 | 5,000.00 | 98.1% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 270,000.00 | 265,000.00 | 5,000.00 | 98.1% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32,814,100.00 | 32,814,100.00 | - | 100.0% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,814,100.00 | 32,814,100.00 | - | 100.0% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,814,100.00 | 32,814,100.00 | - | 100.0% |
|  | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,273,311,100.00 | 1,267,448,362.71 | 5,862,737.29 | 99.5% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,273,311,100.00 | 1,267,448,362.71 | 5,862,737.29 | 99.5% |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,273,311,100.00 | 1,267,448,362.71 | 5,862,737.29 | 99.5% |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,500,000.00 | 4,082,500.00 | (1,582,500.00) | 163.3% |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 58.00 | 51.00 | 7.00 | 87.9% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 58.00 | 51.00 | 7.00 | 87.9% |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 55.00 | 46.00 | 9.00 | 83.6% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 4.00 | (2.00) | 200.0% |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **804,774,009.00** | **1,163,558,720.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **804,774,009.00** | **1,163,558,720.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 804,774,009.00 | 1,163,558,720.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 804,774,009.00 | 1,163,558,720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 804,774,009.00 | 1,163,558,720.00 |
| 2133 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,390,506.80** | **7,032,300.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,390,506.80 | 7,032,300.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 807,164,515.80 | 1,170,591,020.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 807,164,515.80 | 1,170,591,020.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 657,112,460.00 | 728,098,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 149,644,055.80 | 442,493,020.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагын нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад байгууллагын эрхэм зорилго оршино. Мал амьтны эрүүл мэндийн алба 5, захиргаа, санхүүгийн алба 7, мал эмнэлгийн лаборатори 5, мал эмнэлгийн тасагт 40 орон тоо нийт 58 орон тоо батлагдсанаас 51 орон тоотойгоор мал эмнэлгийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. 2023 онд 1,275,811.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийг 0.3 хувиар хэмнэсэн байна.

Орон нутагт голомтлон гардаг Мал, амьтны 13 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх технологит дархлаажуулалтын арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй, чанартай зохион байгуулснаар халдварт өвчний гаралт 53 хувиар буурсан байна. 2023 оны мал, амьтны гоц халдварт өвчингүй эрүүл бүс статусаа хадгалж чадсан байна. Мөн 2023 онд Монгол улсад Шинжлэх ухааны мал эмнэлэг үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой тохиож өнгөрсөн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241-р тогтоолоор цалинг шинэчлэн тогтоосон.

Мал эмнэлгийн газрын Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны дотоод аудитын нэгж нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг 2023 онд дотоод аудит хийгдээгүй байна.

Баянхонгор аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс тус байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба гүйцэтгэлийн тайланг 90.6 хувиар үнэлж 3 алдаа илрүүлж, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс Стандарт хэмжилзүйн газрын нэгдсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 789,137.8 мянган төгрөг буюу 58.8 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 170,362.4 | 12.7% | 223,295.7 | 10.5% | 52,933.4 | 31.1% |
| Мөнгөн хөрөнгө | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Авлага | 1,100.0 | 0.1% | 1,627.7 | 0.1% | 527.7 | 48.0% |
| Бараа материал | 169,262.4 | 12.6% | 221,668.0 | 10.4% | 52,405.6 | 31.0% |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | 1,172,149.7 | 87.3% | 1,908,354.2 | 89.5% | 736,204.5 | 62.8% |
| Үндсэн хөрөнгө | 1,864,742.1 | 138.9% | 2,725,489.0 | 127.9% | 860,746.9 | 46.2% |
| Хуримтлагдсан элэгдэл | (692,592.4) | -51.6% | (817,134.8) | -38.3% | (124,542.4) | 18.0% |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **1,342,512.1** | **100.0%** | **2,131,649.9** | **100.0%** | **789,137.9** | **58.8%** |
| Өр төлбөр | 5,561.1 | 0.4% | - | - | (5,561.1) | -100.0% |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,336,951.0 | 99.6% | 2,131,649.9 | 1.0 | 794,698.9 | 59.4% |
| **ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,342,512.1** | **1.0** | **2,131,649.9** | **1.0** | **789,137.8** | **58.8%** |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байхгүй. Авлагын дансанд "Синапс" ХХК-аас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөөс лабораторийн барилга баригдаж дууссаны дараа ашиглах хөрөнгийг аваагүй тул 1,100.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Мөн Ник ХХК-аас 527.7 мянган төгрөгийн авлагатай гарсныг 2024 оны эхэнд шатахууны картыг тус дүнгээр цэнэглэж авлагыг барагдуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 221,668.0 мянган төгрөг болж 52,405.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 325,366.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 664,885.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй авсан ба Мал эмнэлгийн ерөнхий газраас 633,790.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, эм боох материал, Онцгой байдлын газраас 4,405.0 мянган төгрөгийн эм боох материал, УМЭАЦТЛ-оос 12,412.0 төгрөгийн эм боох материалын орлого авч нийт 990,252.4 мянган төгрөгийн бараа материалын орлого авч, 937,846.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 221,668.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Бараа материалын эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг хэрэглэдэг.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,725,489.0 мянган төгрөг болж 860,746.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 7,767.5 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ХХААХҮ-ийн сайдын А/378 тоот тушаалаар ариутгал халдваргүйтгэлийн тусгай зориулалтын 15 ширхэг 975,000.0 мянган төгрөгийн өртөгтэй ДУК автомашин, мэргэжлийн хяналтын газраас шилжиж ирсэн 2,747.9 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан байна. Мөн ашиглалтын хугацаа дуусч, элэгдэх өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 25 нэр төрлийн 174,459.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 813 дугаар тогтоолоор ашиглах хугацаа, үнэлгээг дахин тогтоож 56,894.7 мянган төгрөгөөр шинэчлэн бүртгэсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 837 тоот тогтоолоор ашиглах боломжгүй, элэгдлээ бүрэн нөхсөн 17 нэр төрлийн 7,203.8 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийг акталж, данснаас хассан.

Тайлант оны эхэнд 5,561.1 мянган төгрөгийн өртэй байсныг тухайн онд төлж барагдуулсан байна. Жилийн эцсийн байдлаар урт болон богино хугацаат дансны өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,131,649.9 мянган төгрөг болж 794,698.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр дүн 13,810.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,096,945.3 мянган төгрөг, өөрийн орлогоор 2,000.0 мянган төгрөг, нийт 1,098,945.3 мянган төгрөг , нийт зарлагыг 1,098,945.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 135,501.4 мянган төгрөгөөр бууруулж 963,443.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн хуваарьт тодотгол хийж 312,367.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,273,311.1 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлого 4,082.5 мянган төгрөг, нийт 1,277,393.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 5,862.7 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,271,530.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,271,530.9 мянган төгрөг буюу 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 2,880.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 850.3 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 241.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 308.0 мянган төгрөгөөр хэмнэж, батлагдсан төсвийг нийт 4,280.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70801 Мал аж ахуйг хөгжүүлэх** | | 638,679.2 | 638,637.6 | 41.6 | 100.0% |
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 638,679.2 | 638,637.6 | 41.6 | 100.0% |
| **70805 Хөдөө аж ахуй газар тариалангийн бодлого** | | 637,131.9 | 632,893.3 | 4,238.6 | 99.3% |
| 4 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 604,317.8 | 600,079.2 | 4,238.6 | 99.3% |
| 5 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 32,814.1 | 32,814.1 | 0.0 | 100.0% |
| | **Нийт** | **1,275,811.1** | **1,271,530.9** | **4,280.2** | 99.7% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 420,232.5 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ЗДТГазраас 728,098.0 мянган төгрөг, УМЭАЦТөв лаборатори 22,260.5 мянган төгрөг нийт 1,170,591.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосныг шатахууны зардалд 10,240.5 мянган төгрөг, вакцины үнэнд 331,304.3 мянган төгрөг, томилолтын зардал 4,860.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 817,153.0 мянган төгрөгийг зарцуулж, 7,032.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллаагааны төлөвлөгөө батлаагүй бөгөөд түлш халаалтын зардалд нийт 15,079.4 мянга, гэрэл цахилгааны зардалд 4,433.2 мянга, цэвэр бохир усны зардалд 3,405.2 мянган төгрөг батлагдсанаас Тахилгат дулаан цагаан хайрхан ХХК , Чандмань Баянхонгор ХК-иудтай дулаанаар хангах гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, "Чандмань-Баянхонгор"ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал буюу 2,578,776.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,787.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,051.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж цахилгааны зардлыг 731.9 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 113.5 мянган төгрөгөөр нийт ашиглалтын зардлыг 850.3 мянган төгрөгөөр хэмнэж өр, авлага үүсгээгүй ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн алдаа зөрчил байхгүй.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 3,806,890.3 мянган төгрөгийн 147 мэдээлэл, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д

заасан 58 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Хугацаа хоцорсон болон мэдээлээгүй гэрээ, шийдвэр байхгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 7,049.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 01/90 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 561.8 | 2 | 561.8 | 100% |
| Албан шаардлага | 2 | 6,487.4 | 2 | 6,487.4 | 100% |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **7,049.2** | **1** | **7,049.2** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох нөхцөл байдал илрээгүй.

### 5.2 Албан шаардлага

### 5.3 Зөвлөмж[1]

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| - | - | - | | | - | - | - | - | | |
| - | - | - | - | - | | | - | - | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | | |

[1] Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зйүлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| . | - | 0 | | | - | 0 | | |
| Дүн | **-** | **0** | | | **-** | **0** | | |

------------oOo------------